



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2022 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 05

Чингис хот

2022-2023 оны Мал аж ахуйн өвөлжилт,
хаваржилт болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай

Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг байгалийн болзошгүй гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг орон нутгийн төр, захиргааны байгууллага, малчид, иргэд, аж ахуйн нэгжийн түвшинд сайтар ханган биелүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2022 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 277 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2022 оны “2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай” 09 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

1. Сумдын Засаг дарга нарт даалгах нь:

1.1. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах чиглэлээр:

1.1.1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 20-ны 277 дугаар тогтоолын дагуу сумын аюулгүйн нөөцөд 80 тн өвс, 40 тн тэжээл бэлтгэж 10 дугаар сарын 01-ний дотор хадгалах цэгт байршуулах. (аймаг, сумдын өвс, тэжээлийн нөөц болон малчдын бэлтгэх өвс, тэжээлийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар батлав).

1.1.2. Хадлан бэлтгэх боломжгүй сумдын аюулгүй нөөцийн өвсийг хадлангийн нөөц талбай бүхий сумдын удирдлагатай харилцан тохиролцож хадлангийн талбай ашиглах гэрээ хэлцлийг хийх ажлыг зохион байгуулах.

1.1.3. Мал сүрэгт намрын үзлэг ангилалт, заазлалт, ээмэгжүүлэлт бүртгэлжүүлэлтийн ажлыг мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран зохион байгуулах,

1.1.4. Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироонд судалгаа хийж, тохироогоор дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн бойжуулах, худалдан авах, хээлтэгч малыг

биотехнологийн дэвшилтэт арга ашиглан зохиомлоор хээлтүүлэх ажлыг орон нутагт нэвтрүүлэх.

1.1.5.Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутаг, Хилийн зурвас газар, Улсын тусгай хамгаалалттай газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргах, холбогдох төрийн байгууллагаас зөвшөөрөл авч малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамрагдсан малыг отроор өвөлжүүлж хаваржуулах ажлыг зохион байгуулах. Сэжигтэй мал, амьтныг нэвтрүүлэхгүй байх бүх талын арга хэмжээ авч ажиллах.

1.1.6.Сумын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийн хил заагийг тодорхойлж, өөрийн аймаг, сумын малыг отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах.

1.1.7.Малчид болон Отроор өвөлжиж, хаваржих малчдыг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 15-ны А/139 дүгээр тушаалаар "Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвснөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах, нийгмийн үйлчилгээ үзүүлэх ажлыг өөрийн харьяаллын эрүүл мэндийн төв, мал эмнэлгийн газруудтай хамтран зохион байгуулж, оторлож буй малчдад цар тахлын халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах, хүн, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

1.1.8.Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй хортон мэрэгч, шавьжтай тэмцэх ажлыг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг хүлээн авах, тайлагнах.

1.1.9.Малын тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, сумын аюулгүйн нөөцийг бүрдүүлэхээс гадна малчдад малын тэжээл худалдан борлуулах ажлын уялдааг сайжруулах.

1.1.10.Үр тарианы сүрэл, тэжээлийн ургамлын иш, навч болон таана, хөмүүл, халгай, лууль зэрэг ургамлуудыг даршлах гар тэжээл бэлтгэх арга, технологийг малчдад зааж сурган бэлтгүүлэх ажлыг зохион байгуулах.

1.1.11.Сумын бэлчээрийн даацад судалгаа хийж, даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, төв суурингийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

1.1.12.Бэлтгэсэн мах, дайвар бүтээгдэхүүнийг түр хугацаанд хадгалах эрүүл ахуйн шаардлага хангасан агуулах бэлтгэх, төв суурин газрын махны үйлдвэр, худалдаа

үйлчилгээний төв, аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан борлуулах, тээвэрлэх ажлыг зохион байгуулах.

1.1.13.Бэлтгэсэн малын арьс, ширэнд анхан шатны боловсруулалт хийх, мэргэжлийн холбоодтой хамтран худалдан борлуулах ажлыг зохион байгуулах

1.1.14.Төвлөрсөн хот, суурин газрын хүн амын өвөл, хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх, мах экспортод гаргах зорилгоор “эрүүл бүс” бий болгох асуудлыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулах.

1.1.15.Цаг агаарын улирлын урьдчилсан төлөв байдлын мэдээ, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн богино, дунд хугацааны урьдчилсан мэдээг малчид, иргэдэд шуурхай хүргэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ тогтмол авах.

1.1.16.Малчин өрх бүрийн худаг, уст цэг, өвөлжөө, хашаа, хорооны хүрэлцээ хангамжийн тооцоог сум, баг, малчин өрх бүрээр гаргах, малын хашаа хороог засварлах, цаг агаар хүндэрсэн үед хэрэглэх тоног хэрэгсэл, дулаан хувцас, хоол хүнс, түлээ, нүүрс, өтөг бууц зэрэг өрхийн өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулах ажлыг зохион байгуулах.

1.1.17.Мал сүрэгт үзлэг ангилалт хийх, ээмэгжүүлэн бүртгэлжүүлэх, өвс тэжээлийн аюулгүйн нөөцийн өвс бүрдүүлэх, тэжээлийн агуулах, саравч барих зэрэг хөдөө аж ахуйн холбогдолтой ажил үйлчилгээг малын тоо толгойн албан татвар болон арьс шир, ноосны урамшууллын 10 хувийн хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

1.1.18.Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, орлого бүрдүүлэлтэд тавих хяналтыг эрчимжүүлж ажиллах.

1.2.Ургац хураалтын бэлтгэл хангах чиглэлээр

1.2.1.Ургац хураалтад ажиллах хүн, хүч, техник, үтрэм агуулах, элеватор, зоорийн засвар үйлчилгээ, ариутгалыг холбогдох заавар, журмын дагуу хэрэгжүүлж, шатах тослох материалын нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах.

1.2.2.Ургацыг малаас хамгаалах, ургац хараалтын ажил дуусах хүртэл тариалангийн талбайн ойр орчимд малчин, мал бүхий этгээдийг суурьшуулахгүй байх, малыг байнгын хариулгатай байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах:

1.2.3.Ургацын урьдчилсан балансыг таримлын төрөл тус бүрээр нарийвчлан 2022 оны 8 дугаар сарын 15-ны дотор гаргах, хураах арга технологийг боловсруулах, ургац хураалтын ажлыг шуурхай зохион байгуулах, ургацын салбар штабыг байгуулж уртасгасан цагаар ажиллуулах.

4.

1.2.4. Намрын ургацаас хураасан хүнсний улаан буудайг биржээр арилжаалах арга хэмжээг тариаланч, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллах

1.2.5. Тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн бүр дотоодын ургацаасаа боловсруулж бэлтгэсэн уриншдаа хүрэлцэхүйц хэмжээний үрийн буудайн нөөц бүрдүүлэх,

1.2.6. Сортын үрийн хянан баталгааг хугацаанд нь хийж, стандартын шаардлагад нийцүүлэх, ногооны зоорь үтрэмийн цэвэрлэгээ, ариутгал, бүтээгдэхүүний хадгалалтад байнгын хяналт тавьж ажиллах

1.2.7. Тариалан бүхий сумд аж ахуйн нэгжүүдтэй уялдаа холбоотой ажиллаж, ургац хураалтын явцад тогтмол хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг богино хугацаанд шуурхай шийдвэрлүүлж ажиллах,

1.2.8. Газар тариалангийн мэдээллийн нэгдсэн санд тариаланчид, тариалангийн талбай, ургацыг бүртгэх цахим системийг нэвтрүүлж, гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгох ажлыг зохион байгуулах.

1.3. Хөдөө аж ахуйн өвөлжилт, хаваржилт болон ургац хураалтын бэлтгэл хангах ажлыг ковид-19 цар тахалтай холбогдуулан халдвар хамгааллын дэглэмийг чанд сахин, холбогдох байгууллагаас гаргасан дүрэм журмыг мөрдүүлж ажиллах.

1.4. 2022-2023 оны Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хадлан тэжээл бэлтгэлийн мэдээг 7 хоног бүрийн лхагва гарагт, биелэлт болон сумын мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангасан нэгдсэн дүнг загвар хүснэгтийн дагуу гаргаж 10 дугаар сарын 01-ний дотор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт ирүүлэх.

2. Хүнс, Хөдөө аж ахуйн газарт даалгах нь:

2.1. Энэхүү албан даалгаврыг аймгийн нийт ард иргэд, малчдад хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслээр дамжуулан сурталчлах ажлыг зохион байгуулах.

2.2. Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах тухай "Албан даалгавар"-ыг сумдад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж, хадлан тэжээл бэлтгэх боломжгүй сумдыг хадлан тэжээл бэлтгэх боломжоор хангах асуудлыг шийдвэрлэж, хадлан тэжээл бэлтгэлийн мэдээг 7 хоног бүр сумдаас авч нэгтгэн холбогдох байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангаж ажиллах.

2.3. Албан даалгаврын хэрэгжилт болон Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 20-ны 277 дугаар тогтоолын дагуу аймгийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс,

5.

50 тн тэжээл, сумын аюулгүйн нөөцөд 80 тн өвс, 40 тн тэжээл бэлтгэх биелэлт, аймгийн мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангасан нэгдсэн тайланг “Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар”-ын дагуу гаргаж 2022 оны 10 дугаар сарын 15-ны дотор Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн хөгжлийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэх.

2.4.Газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хадгалж, уринш боловсруулалт, ургамал хамгааллын арга хэмжээ, ургац хураалтын явцад ажиллах хүч, техникийн бэлэн байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх.

2.5.Бэлчээр, ургамал хамгааллын ажлыг технологийн дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт дор зохион байгуулах.

3. Мал эмнэлгийн газарт даалгах нь:

3.1.Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж, мал эмнэлгийн дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг бүрдүүлж, шуурхай удирдлагаар хангах.

3.2.Мал сүрэгт намрын угаалга, туулгалт, вакцинжуулалт зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд чанартай зохион байгуулж, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хүртээмжтэй хангах,

3.3.Мал сүргийн хамуу, хүрд, ширх, гуур зэрэг эктопаразитаас хамгаалах арга хэмжээг 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн хэрэгжүүлж, өвөлжөө хаваржаанд паразитын устгал, ариутгал хийх арга хэмжээг зохион байгуулах.

3.4.Малын шилжилт хөдөлгөөнийг сүртгэх, хянах, хязгаарлахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

3.5.Мал эмнэлгийн бэлэн байдлын нөөцөд үнэлгээ хийж, нөөцийг нөхөн бүрдүүлэх,

4. Онцгой байдлын газарт даалгах нь

4.1.Орон нутгийн өвөлжилт, хаваржилгын нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд аймгийн аюулгүй нөөцийн өвс, тэжээл, тусламжийн бараа хүргэхэд хүн хүч, техникийн туслалцаа үзүүлэх, орон нутгийн гамшгаас хамгаалах мэргэжлийн албын бэлтгэл бэлэн байдалд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангах.

6.

5. Боловсрол, шинжлэх ухааны газарт даалгах нь:

5.1. Намрын ургац хураалтад сурагчдыг идэвхтэй татан оролцуулах зорилгоор сургалтын хөтөлбөрт хөдөлмөрийн дадал, ур чадвар олгох хэлбэрээр хичээлийн агуулгыг тусган оруулах боломжийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран судалж, танилцуулах.

6. Орон нутгийн өмчийн газарт даалгах нь:

6.1. Өвөл, хаврын ган зудын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирол багатай даван туулах зорилгоор Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 20-ны 277 дугаар тогтоолын дагуу аймгийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс, 50 тн тэжээл бэлтгэж, татан авч нөөцлөх.

7. Харгуй ТӨХК-д даалгах нь:

7.1. Зам, давааг өвөл, хаврын улиралд байнгын нээлттэй байлгах зорилгоор хүн хүч, техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах.

8. Албан даалгаврыг хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтаар хангах, гүйцэтгэлийг хянан шалгах, үр дүнг 2022 оны 10 дугаар сарын 15-ны дотор танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
2022 оны.....дугаар сарын.....-ны
05..... дугаар албан даалгаварын хавсралт

АЙМАГ, СУМДЫН АЮУЛГҮЙН НӨӨЦ БОЛОН
МАЛЧДЫН БЭЛТГЭХ ӨВС, ТЭЖЭЭЛ

№	Сумын нэр	Засгийн газрын 2022 оны 277 дүгээр тогтоолын дагуу аймаг, сумдын аюулгүйн нөөцөд бэлтгэх		Малчин өрхийн хэрэгцээнд зориулан бэлтгэх		
		Өвс /тн/	Тэжээл /тн/	Өвс /тн/	Тэжээл /тн/	Гар тэжээл /тн/
1	Галшар	80	40	1000	10	5
2	Баянхутаг	80	40	1000	10	5
3	Баянмөнх	80	40	1000	10	5
4	Дархан	80	40	1000	10	5
5	Дэлгэрхаан	80	40	2000	10	5
6	Жаргалтхаан	80	40	2000	10	5
7	Цэнхэрмандал	80	40	2000	10	5
8	Өмнөдэлгэр	80	40	20000	10	5
9	Батширээт	80	40	10000	10	5
10	Биндэр	80	40	13000	10	5
11	Баян-Адарга	80	40	13000	10	5
12	Дадал	80	40	30000	10	5
13	Норовлин	80	40	10000	10	5
14	Батноров	80	40	8000	10	5
15	Баян-Овоо	80	40	3500	10	5
16	Мөрөн	80	40	3500	10	5
17	Хэрлэн	80	40	8000	10	5
18	Бор-Өндөр	80	40	1000	10	5
Сумдын дүн		1440	720	130000	180	90
Аймгийн нөөц		150	50	-	-	-
Нийт дүн		1590	770	130000	180	90